



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 2/2018

Чингис хот

Тусгай зөвшөөрөл сунгах, хүчингүй болгох,
түдгэлзүүлэх, нэр шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5, 6 дугаар зүйлийн 6.2, 14 дүгээр зүйлийн 14.1.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтууд, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Согтууруулах, ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дараах аж ахуйн нэгжүүдийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн хоёр жилийн хугацаатайгаар сунгасугай.

Хүнсний дэлгүүр:

- | | |
|---------------------|------------------------|
| 1. Хэрлэн сум | "Их баян бүрд" ХХК |
| 2. Хэрлэн сум | "Хан Уулын хишиг" ХХК |
| 3. Хэрлэн сум | "Атарчандгана" ХХК |
| 4. Бор-Өндөр сум | "Морьтны даваа" ХХК |
| 5. Биндэр сум | "Амжилт" ХХК |
| 6. Батширээт сум | "Баярмөнгөнбум" ХХК |
| 7. Батширээт сум | "Утга" ХХК |
| 8. Батширээт сум | "Алтаргана хүнс" ХХК |
| 9. Баянмөнх сум | "Галтхаан" ХХК |
| 10. Баян-Овоо сум | "Ханзат" ХХК |
| 11. Баян-Овоо сум | "Зуун сарнай" ХХК |
| 12. Баян-Адарга сум | "Өгөөмөр онон" ХХК |
| 13. Баян-Адарга сум | "Эрдэнэпил" ХХК |
| 14. Бэрх тосгон | "Ононшанд" ХХК |
| 15. Дархан сум | "Дархан цээл" ХХК |
| 16. Жаргалтхаан сум | "Ариунтүмэн" ХХК |
| 17. Өмнөдэлгэр сум | "Ноёнжаргалант" ХХК |
| 18. Өмнөдэлгэр сум | "Хэнтийн жон ван" ХХК |
| Баар: | |
| 19. Батширээт сум | "Алтаргана хүнс" ХХК |
| 20. Дэлгэрхаан сум | "Хүннү хөдөө арал" ХХК |
| Зоогийн газар: | |
| 21. Бор-Өндөр сум | "Сувдан зурхай" ХХК |

211010636

2.

2. Хэрлэн сумын "Элстэйн ар булаг" ХХК-ийн хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс хүчингүй болгосугай.

3. Өмнөдэлгэр сумын "Юмт гэгээ" ХХК-ийн хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн 3 сар хүртэлх хугацаатайгаар түдгэлзүүлсүгэй.

4. Батширээт сумын "Баярмөнгөнбум" ХХК-ийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг Баваасан овогтой Мөнхбаатар, Дэлгэрхаан сумын "Ирмүүн Эрдэнэ" ХХК-ийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг Энхчимэг овогтой Нармандах, Жаргалтхаан сумын "Ариунтүмэн" ХХК-ийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг Аюурзана овогтой Наранцэцэг нарт тус тус шилжүүлсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэхэд хяналт тавих аймгийн комисс, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Стандарт, хэмжилзүйн хэлтэс, Татварын хэлтэс, холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Энэхүү захиргааны актыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд албан ёсоор гардаж авснаас хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА